

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ӨРХ, ХҮН АМЫН ТАНИЛЦУУЛГА



2019

УЛААНБААТАР ХОТ 2020 ОН



ХЯНАСАН:

Д.Мөнхзул

ЧД-ийн Статистикийн хэлтсийн дарга

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:

М.Батхишиг

ЧД-ийн Статистикийн хэлтсийн ахлах
мэргэжилтэн

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС
МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, САМБУУГИЙН ГУДАМЖ
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
БАЙР, 401 тоот
Утас: 70113013
70130767
70110767
976-11-310767

Цахим хуудас: www.ubstat.mn
www.chingeltei.gov.mn

И-мэйл: chingeltei@nso.mn




ХҮН АМЫН ҮЗҮҮЛЭЛТ

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн нийт хүн ам 2019 онд 148977 болж, өмнөх оноос 8281 (5.3%) хүнээр бүүрчээ. Дүүргийн хэмжээнд 2019 онд 3863 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оноос 233 (6.4%) хүүхдээр өссөн байна.

Хүснэгт 1. Монгол Улс, Нийслэл хотын хүн амын тоо, дүүргээр, оноор

Засаг захиргаа	2015	2016	2017	2018	2019
Монгол Улсын нийт хүн ам	3 057 778	3 119 935	3 131 750	3 186 347	3 197 020
Нийслэлийн дүн	1 345 500	1 380 792	1 417 396	1 444 669	1 466 125
Чингэлтэй	154 819	158 014	159 051	157 258	148 977
Багануур	28 419	28 973	28 787	29 512	28 570
Багахангай	4 131	4 143	4 100	4 399	4 123
Баянгол	205 663	214 278	221 384	226 869	225 840
Баянзүрх	320 852	327 123	336 932	343 619	361 689
Налайх	35 813	36 425	36 911	37 608	37 659
Сонгиохайрхан	307 224	315 802	322 458	321 150	327 580
Сүхбаатар	137 633	136 569	138 047	145 335	144 409
Хан-Уул	150 946	159 465	169 726	178 919	187 278

Чингэлтэй дүүрэгт Нийслэл хотын хүн амын 10.1 хувь, Монгол Улсын хүн амын 4.7 хувь нь байнга оршин сууж байна. Дүүргийн нутаг дэвсгэрийн нийт хэмжээ 8.9 мянган га бөгөөд нэг километр квадрат талбайд 1668 хүн ногдож байна.



Төрөх үеийн хүйсийн харьцаа 102.4 байгаа нь шинэ төрсөн 100 охин хүүхэд тутамд 102 эрэгтэй хүүхэд мэндэлж буйг харуулж байна. Харин 2019 оны суурин хүн амын тоогоор хүйсийн харьцаа 94.9 байгаа нь дүүргийн 100 эмэгтэй тутамд 95 эрэгтэй ногдож байна. Уг үзүүлэлтийн улсын дүн 97.3, нийслэлийн дүн 94.0 байна.

Хүн амын дундаж наслалт 2019 онд улсын дундаж 70.41, нийслэлийн дундаж 71.8 байна. Монгол эмэгтэйчүүдийн дундаж наслалт 75.96 байгаа нь эрэгтэй хүний дундаж наснаас 9.58 насаар өндөр байна.


Хүснэгт 2. Чингэлтэй дүүргийн хүн амын тоо, хороогоор, оноор

Хороо	2015	2016	2017	2018	2019
Дүүргийн дүн	154 819	158 014	159 051	157 258	148 977
1 -р хороо	3 872	3 928	3 900	4 232	3 836
2 -р хороо	3 268	3 328	3 431	3 414	3 597
3 -р хороо	5 439	5 605	6 060	6 766	6 274
4 -р хороо	5 030	4 848	5 219	5 118	4 951
5 -р хороо	4 699	5 319	4 911	5 229	4 743
6 -р хороо	7 424	7 393	7 523	7 987	8 395
7 -р хороо	12 827	13 048	13 596	12 834	11 917
8 -р хороо	4 546	4 483	4 535	4 354	3 882
9 -р хороо	7 420	7 569	7 247	7 364	6 413
10 -р хороо	7 905	8 328	8 096	7 946	7 341
11 -р хороо	6 040	5 958	5 776	5 585	5 377
12 -р хороо	14 691	15 073	15 665	15 248	14 314
13 -р хороо	8 137	8 361	8 275	8 203	7 670
14 -р хороо	7 948	8 054	7 580	7 694	6 850
15 -р хороо	8 539	8 583	8 945	9 226	8 532
16 -р хороо	12 614	12 714	12 751	12 202	12 655
17 -р хороо	14 247	13 798	13 860	13 372	13 299
18 -р хороо	9 336	9 721	9 784	9 082	8 300
19 -р хороо	10 837	11 903	11 897	11 402	10 631

Суурин хүн ам гэдэг нь тухайн нутаг дэвсгэрт 183 хоног, түүнээс дээш хугацаагаар байнга оршин сууж буй юм. Дүүргийн суурин хүн амын тоо 148977 болж өмнөх оноос 8281 хүнээр буюу 5.3 хувиар буурчээ. Хүн амын тоо өмнөх оноос буурахад шилжин явалт их байгаа нь голлон нөлөөлсөн байна.


Дүүргийн хороодын хүн амын тооны дундаж 7841 байгаа бол дунджаас их хүн амтай 8 хороо, дунджаас бага хүн амтай 11 хороо байна. Хамгийн их хүн амтай 12 дугаар хороонд 14314 хүн байнга оршин сууж байгаа нь дүүргийн нийт хүн амын 9.6 хувийг эзэлж байна.

Зураг 1. Хороодын хүн амын тоо



Дүүргийн хүн амын тоо 1992 оноос 72402 (85.3%) хүнээр, 2010 оноос 9820 (6.7%) хүнээр тус тус өссөн байна. Зурагнаас харахад жилийн дундаж өсөлтийн хурд аажмаар буурах хандлага ажиглагдаж байна. Сүүлийн жилүүдэд Нийслэлийн хэмжээнд орон сууцны хороолол, хотхон ихээр баригдаж байгаа боловч Чингэлтэй дүүргийн хороодод томоохон орон сууцны хороолол, хотхон баригдахгүй байгаа нь хүн хүн амын өсөлтийн хурд саарахад голлон нөлөөлж байна.

Зураг 2. Хүн амын тоо, жилийн дундаж өсөлт, оноор



Хүснэгт 3. Хороодын хүн амын тоо, хүн ам зүй ачаалал 2019 он

Хороод	Нийт хүн ам			Хүн ам зүйн ачаалал ¹	0-14 насны хүүхдийн ачаалал	65, түүнээс дээш өндөр настны ачаалал
		Эрэгтэй	Эмэгтэй			
Дүүргийн дүн	148 977	72 538	76 439	55.9	48.7	7.2
1 -р хороо	3 836	1 707	2 129	68.2	53.4	14.8
2 -р хороо	3 597	1 678	1 919	67.3	55.4	11.8
3 -р хороо	6 274	2 837	3 437	67.7	56.9	10.8
4 -р хороо	4 951	2 263	2 688	53.4	42.9	10.5
5 -р хороо	4 743	2 189	2 554	60.5	46.7	13.8
6 -р хороо	8 395	3 924	4 471	61.0	52.4	8.6
7 -р хороо	11 917	5 913	6 004	53.7	48.2	5.5
8 -р хороо	3 882	1 877	2 005	50.9	42.5	8.4
9 -р хороо	6 413	3 148	3 265	50.8	43.8	7.0
10 -р хороо	7 341	3 623	3 718	52.7	47.4	5.3
11 -р хороо	5 377	2 665	2 712	51.1	45.3	5.8
12 -р хороо	14 314	7 019	7 295	54.7	50.2	4.5
13 -р хороо	7 670	3 737	3 933	54.5	48.3	6.2
14 -р хороо	6 850	3 425	3 425	52.4	45.8	6.5
15 -р хороо	8 532	4 157	4 375	57.0	50.5	6.4
16 -р хороо	12 655	6 351	6 304	54.5	48.6	5.9
17 -р хороо	13 299	6 601	6 698	55.8	49.0	6.8
18 -р хороо	8 300	4 088	4 212	52.6	47.0	5.6
19 -р хороо	10 631	5 336	5 295	58.9	50.1	8.8

¹ 15-64 насны 100 хүнд ногдох хүүхэд, өндөр настны тоо

Дүүргийн нийт хүн амын 72538 буюу 48.7 хувь нь эрэгтэй, 76439 буюу 51.3 хувь нь эмэгтэйчүүд байна.

Хүн ам зүйн ачаалал 2019 онд 55.9 болж өмнөх оноос 3.4 пунктээр нэмэгдсэн байна. Энэ нь хөдөлмөрийн насны 100 хүн тутамд 49 хүүхэд, 7 өндөр настан ногдож байгааг харуулж байна.

Уг үзүүлэлтийг хорооны түвшинд авч үзвэл 1 дүгээр хороонд хамгийн өндөр буюу 68.2 хувь, 53 нь

хүүхэд, 15 нь хөгшид байна. Дүүргийн 1, 2, 3, 5, 6 хороод нь Нийслэл хотын төв хэсэгт байрладаг бөгөөд хүн ам зүйн ачаалал мөн өндөр үзүүлэлттэй гарсан байна. Чингэлтэй дүүргийн орон сууцны хороодод Нийслэл хотын анхны орон сууцны барилгууд байрладаг ба өндөр настнууд байрандаа тогтвортой амьдардаг нь нөлөөлж байна. Мөн сургууль, цэцэрлэгийн хүрэлцээ муутай үед хотын төвийн сургуульд хүүхдээ сургах гэсэн иргэдийн шилжилт хөдөлгөөн нөлөөлж байна.




Төрөлт нас баралтын зөрүүгээр хүн амын тоо 2899 хүнээр нэмэгдсэн байна. Ердийн цэвэр өсөлтийн коэффициент 17.6 промил байгаа нь 1000 хүн ам тутамын 18 хүн нь шинээр мэндэлсэн хүүхэд байна. Иргэний бүртгэлийн шинэ хуулийн дагуу тухайн иргэн шилжин явж буй тохиолдолд үндсэн баг, хорооноос хасалт хийгдэхгүй болсонтой холбоотойгоор шилжин явж буй иргэний мэдээлэл бүртгэгдэхгүй болсон учраас шилжилт хөдөлгөөний мэдээлэл тооцоонд ороогүй болно.

Хүснэгт 4. Хүн амын ердийн болон механик өсөлт, өсөлтийн коэффициент, оноор

Он	Төрөлт	Нас баралт	Ердийн цэвэр өсөлт	Ердийн цэвэр өсөлтийн коэффициент	Шилжин ирсэн	Шилжин явсан	Механик өсөлт	Шилжих хөдөлгөөний цэвэр өсөлтийн коэффициент
2010	3 594	1 024	2 570	17.9	14 421	10 796	3 625	25.2
2011	3 960	1 071	2 889	19.2	11 803	9 015	2 788	18.6
2012	4 659	1 065	3 594	23.4	8 546	8 206	340	2.2
2013	4 608	841	3 767	24.3	8 757	8 644	113	0.7
2014	4 638	1 006	3 632	23.0	10 050	9 967	83	0.5
2015	4 751	960	3 791	24.1	8 596	9 402	-806	-5.1
2016	4 475	916	3 559	22.8	10 682	11 841	-1 159	-7.4
2017	3 764	960	2 804	17.7	9 082	14 152	-5 070	-32.0
2018	3 756	857	2 899	18.4	8 707	13 847	-5 140	-32.5
2019	3 863	896	2 967	17.6	9 235	-	-	-

Зураг 3-аас харахад 2010 онд дүүргийн 1000 хүн тутамд шилжих хөдөлгөөний зөрүүгээр 25 хүнээр, төрөлт, нас баралтын зөрүүгээр 18 хүнээр нэмэгдэж, хүн амын өсөлтийн хурд эерэг буюу 5.5 хувьтай байсан бол 2015 оноос шилжих хөдөлгөөний зөрүүгээр 1000 хүн тутамд 5 хүнээр буурч, төрөлт нас баралтын дүнд 24 хүнээр нэмэгдэн жилийн дундаж өсөлтийн хурд 2.9 хувиар буурч эхэлсэн байна. 2019 онд уг үзүүлэлт төрөлт нас баралтын зөрүүгээр 18 хүн нэмэгдэж, өсөлтийн хурд 5.2 хувиар буурсан байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 4.1 пунктээр буурсан байна.

Зураг 3. Хүн амын жилийн дундаж өсөлт, ердийн болон шилжих хөдөлгөөний коэффициент, оноор




Хүснэгт 5. Дүүргийн нутаг дэвсгэрт байнга оршин суугаа хүн амын тоо, нас, хүйсээр, 2019 он

Нас, насны бүлэг	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Нас, насны бүлэг	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	148 977	72 538	76 439	50	1 682	794	888
Нас: 0	3 231	1 622	1 609	51	1 613	735	878
1	3 466	1 805	1 661	52	1 606	740	866
2	3 283	1 753	1 530	53	1 581	716	865
3	3 527	1 825	1 702	54	1 427	638	789
4	3 687	1 862	1 825	50-54 нас	7 909	3 623	4 286
0-4 нас	17 194	8 867	8 327	55	1 577	725	852
5	3 786	1 942	1 844	56	1 452	621	831
6	3 651	1 867	1 784	57	1 463	651	812
7	3 521	1 817	1 704	58	1 251	544	707
8	3 249	1 618	1 631	59	1 310	581	729
9	2 981	1 506	1 475	55-59 нас	7 053	3 122	3 931
5-9 нас	17 188	8 750	8 438	60	1 220	537	683
10	3 060	1 577	1 483	61	1 096	454	642
11	2 802	1 436	1 366	62	979	415	564
12	2 503	1 307	1 196	63	882	364	518
13	1 940	975	965	64	794	333	461
14	1 840	940	900	60-64 нас	4 971	2 103	2 868
10-14 нас	12 145	6 235	5 910	65	728	297	431
15	1 779	904	875	66	595	245	350
16	1 826	988	838	67	526	202	324
17	1 826	926	900	68	409	155	254
18	1 842	903	939	69	542	224	318
19	1 875	921	954	65-69 нас	2 800	1 123	1 677
15-19 нас	9 148	4 642	4 506	70	409	150	259
20	1 871	944	927	71	382	151	231
21	1 825	903	922	72	374	139	235
22	1 895	922	973	73	321	129	192
23	1 883	911	972	74	296	112	184
24	1 981	971	1 010	70-74 нас	1 782	681	1 101
20-24 нас	9 455	4 651	4 804	75	268	93	175
25	2 014	1 003	1 011	76	244	98	146
26	1 873	942	931	77	270	103	167
27	2 365	1 167	1 198	78	204	82	122
28	2 754	1 312	1 442	79	240	101	139
29	2 936	1 470	1 466	75-79 нас	1 226	477	749
25-29 нас	11 942	5 894	6 048	80	141	50	91
30	3 069	1 510	1 559	81	160	72	88
31	3 036	1 525	1 511	82	135	48	87
32	2 842	1 432	1 410	83	109	33	76
33	2 756	1 362	1 394	84	105	39	66
34	2 678	1 303	1 375	80-84 нас	650	242	408
30-34 нас	14 381	7 132	7 249	85	100	32	68
35	2 524	1 283	1 241	86	75	14	61
36	2 316	1 167	1 149	87	65	18	47
37	2 324	1 107	1 217	88	53	17	36
38	2 148	1 076	1 072	89	47	14	33
39	2 132	1 015	1 117	85-89 нас	340	95	245
35-39 нас	11 444	5 648	5 796	90	41	13	28
40	2 092	1 054	1 038	91	29	12	17
41	2 099	1 012	1 087	92	21	8	13
42	2 011	975	1 036	93	16	5	11
43	2 001	908	1 093	94	14	6	8
44	2 008	1 002	1 006	90-94 нас	121	44	77
40-44 нас	10 211	4 951	5 260	95	13	4	9
45	1 918	915	1 003	96	5	3	2
46	1 838	875	963	97	3	0	3
47	1 867	862	1 005	98	2	0	2
48	1 685	813	872	99	1	0	1
49	1 675	783	892	95-99 нас	24	7	17
45-49 нас	8 983	4 248	4 735	100, + нас	10	3	7

Хүн амын нас хүйсийн суварга нь нас хүйсийг ерөнхий бүтцээр нь хуваарилан харахад хамгийн тохиромжтой арга юм. Графикаас харахад 2010 оны хүн амын бүтэц 20-39 насанд өргөссөн нь тухайн үед ажиллах хүчний таатай буюу цонх үе байв, харин 1990-2005 онд төрөлт буурч 5-19 насны хүн амын жин буурч байжээ.

Харин 2019 оны хүн амын бүтцэд сүүлийн жилүүдэд төрөлт нэмэгдсэн нөлөөлж 0-9 насны хүн амын тоо нэмэгдсэн байна. Мөн 25-34 насны хүн ам харьцангуй их байгаа нь хөдөлмөрийн насны залуучууд дийлэнх хэсгийг эзэлж, хөдөлмөр эрхлэлтийн таатай үе үргэлжилж байгааг харуулж байна.

Зураг 3. Хүн амын нас хүйсийн суварга, оноор



Хүснэгт 6. Чингэлтэй дүүргийн суурин хүн амын тоо, насны бүлэг, хүйсээр, оноор

Насны ангилал	2017		2018		2019	
	нийт	эмэгтэй	нийт	эмэгтэй	нийт	эмэгтэй
Нийт дүн	159 051	86 122	157 258	80 779	148 977	76 439
0 нас	3 764	3 764	3 630	1 752	3 231	1 609
1-4	14 847	7 335	15 160	7 362	13 963	6 718
5-9 нас	16 554	8 134	17 254	8 505	17 188	8 438
10-14 нас	10 910	5 370	11 367	5 567	12 145	5 910
15-19 нас	10 074	5 050	9 807	4 836	9 148	4 506
20-24 нас	10 938	5 594	10 520	5 297	9 455	4 804
25-29 нас	16 730	8 630	14 489	7 351	11 942	6 048
30-34 нас	15 612	8 081	15 542	7 794	14 381	7 249
35-39 нас	12 856	6 782	12 177	6 239	11 444	5 796
40-44 нас	11 111	5 860	10 886	5 674	10 211	5 260
45-49 нас	9 585	5 102	9 403	4 962	8 983	4 735
50-54 нас	8 378	4 562	8 435	4 586	7 909	4 286
55-59 нас	6 721	3 771	7 115	3 972	7 053	3 931
60-64 нас	4 297	2 489	4 774	2 766	4 971	2 868
65-69 нас	2 631	1 555	2 624	1 582	2 800	1 677
70, түүнээс дээш нас	4 043	4 043	4 075	2 534	4 153	2 604

Чингэлтэй дүүргийн нийт хүн амын 14283 (9.6%) нь цэцэрлэгийн насны хүүхэд байгаа бол эдгээр хүүхдийн 10584 (74.1%) нь цэцэрлэгт хамрагдаж байна. Харин нийт хүн амын

30978 (20.8%) нь сургуулийн насны хүүхэд байгаа бол эдгээр хүүхдийн 27871 (90.0%) хувь нь сургуульд хамрагдаж байна. Тэтгэврийн насны хүний тоо 15855 болж өмнөх оны мөн үеэс 410 (2.7%)-аар өссөн байна. Дүүргийн хэмжээнд 2019 онд 58 хүн өндөр насны тэтгэвэр тогтоолгоогүй байна.

Хүснэгт 7. Дүүргийн хүн амын тоо, насны ангиллаар, хороогоор, 2019 он

Хороо	Цэцэрлэгийн насны хүүхэд (2-5 нас)		Сургуулийн насны хүүхэд (6-17 нас)		Өндөр настан (эр-60+, эм-55+)	
		эмэгтэй		эмэгтэй		эмэгтэй
Дүүргийн дүн	14 283	6 901	30 978	15 117	15 855	11 080
1 -р хороо	342	154	886	429	598	428
2 -р хороо	343	153	812	380	479	347
3 -р хороо	618	306	1 472	695	836	590
4 -р хороо	393	191	955	498	715	494
5 -р хороо	439	210	930	459	697	487
6 -р хороо	873	417	1 781	863	956	671
7 -р хороо	1 174	579	2 411	1 168	1 038	742
8 -р хороо	358	182	711	346	477	322
9 -р хороо	595	294	1 214	602	681	476
10 -р хороо	681	331	1 535	742	628	452
11 -р хороо	482	219	1 097	540	581	419
12 -р хороо	1 436	694	2 996	1 485	1 210	867
13 -р хороо	763	370	1 526	757	773	560
14 -р хороо	633	314	1 364	649	714	497
15 -р хороо	836	417	1 788	898	825	573
16 -р хороо	1 244	578	2 655	1 282	1 205	828
17 -р хороо	1 292	644	2 808	1 350	1 388	944
18 -р хороо	784	367	1 695	849	817	577
19 -р хороо	997	481	2 342	1 125	1 237	806

Сургуулийн өмнөх боловсрол: 2019-2020 оны хичээлийн жилд төрийн өмчийн 31, төрийн өмчийн бус 22 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байна. Тус хичээлийн жилд цэцэрлэгт 10584 хүүхэд хүмүүжиж байгаа бөгөөд өмнөх оноос 601 (5.3%)-иар буурсан дүнтэй байна. Энэ нь сүүлийн жилүүдэд төрөлт буурч, шилжин явалт ихэсч байгаатай холбоотой.

Ерөнхий боловсролын сургууль: Дүүргийн хэмжээнд 2019-2020 оны хичээлийн жилд төрийн өмчийн 17, төрийн бус өмчийн 8 сургууль үйл ажиллагаа явуулж байна. 2018-2019 оны хичээлийн жилд нийт 27871 хүүхэд суралцаж байгаа бөгөөд суралцагчдын тоо өмнөх оноос 1086 (4.1%) сурагчаар өссөн дүнтэй байна.


Нийт суралцагчдын 13993 (50.2%) эмэгтэй суралцагч байна. 2019 оны хичээлийн жилд 3110 хүүхэд 1 дүгээр ангид элсэн суралцсан байна.

➤ ХАГАС, БҮТЭН ӨНЧИН ХҮҮХЭД

Нийгмийн зарим үзүүлэлтийн судалгаагаар 2019 онд бүтэн өнчин 160 хүүхэд бүртгэгдсэн нь дүүргийн 0-17 насны нийт хүүхдийн 0.3 хувийг эзэлж байна. Бүтэн өнчин хүүхдийн 83 (51.9%) нь эмэгтэй хүүхэд байна. Бүтэн өнчин хүүхдийн тоо өмнөх оноос 1 (0.6%) хүүхдээр буурсан байна. Бүтэн өнчин хүүхдийг насны бүлгээр авч үзвэл 14 (8.8%) нь 0-4 настай, 33 (20.6%) нь 5-9 настай, 49 (30.6%) нь 10-14 настай, 19 (11.9%) нь 15 настай, 29 (18.1%) нь 16 настай, 16 (10.0%) нь 17 настай хүүхэд байна.

2019 онд хагас өнчин 1542 хүүхэд бүртгэгдсэн нь өмнөх оноос 77 (4.8%) хүүхдээр буурсан байна. Дүүргийн 0-17 насны нийт хүүхдийн 3.0 хувь нь хагас өнчин хүүхэд байна. Хагас өнчин хүүхдийн 789 (51.2%) нь эмэгтэй хүүхэд байна. Хагас өнчин хүүхдийг насны бүлгээр авч үзвэл 193 (12.5%) нь 0-4 настай, 434 (28.1%) нь 5-9 настай, 519 (33.7%) нь 10-14 настай, 156 (10.1%) нь 15 настай, 152 (9.9%) нь 16 настай, 88 (5.7%) нь 17 настай хүүхэд байна.


Зураг 7. Хагас, бүтэн өнчин хүүхдийн тоо, оноор



➤ ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭЦЭГ, ЭХ

Өрх толгойлсон хүний тоо 2168 болж өмнөх оны мөн 198 (8.4%) хүнээр буурсан байна. Өрх толгойлсон нийт эцэг, эхийн 1570 (72.4%) нь 18 хүртэлх насны хүүхэдтэй эцэг эх байна. 18 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхийн тоог хүүхдийн тоогоор авч үзвэл 621 (39.5%) нь 1 хүүхэдтэй, 475 (30.3%) нь 2 хүүхэдтэй, 264 (16.8%) нь 3 хүүхэдтэй, 136 (8.7%) нь 4 хүүхэдтэй, 40 (2.5%) нь 5 хүүхэдтэй, 34 (2.2%) нь 6, түүнээс дээш хүүхэдтэй байна. 2008 онд өрх толгойлсон нийт эцэг, эхийн 75 хувь нь өрх толгойлсон эх байсан бол 2019 онд уг үзүүлэлт 84.9 хувь болж 9.9 промиллээр өссөн байна.

Зураг 8. Өрх толгойлсон эцэг, эхийн тоо, 2008, 2019 он



Нийгмийн зарим үзүүлэлтийн 2019 оны судалгаагаар дүүргийн хэмжээнд алдарт эхийн одонтой 6945 эх байгаагийн 1822 (26.3%) нь алдарт эхийн I одонтой эх, 5123 (73.7%) алдарт эхийн II одонтой эх байна.

Алдарт эхийн I одонтой эхийн хүүхдийн нийт тоо 11809 бол 1 эхэд ногдох хүүхдийн дундаж тоо 6.5, алдарт эхийн II одонтой эхийн нийт хүүхдийн тоо 20525 бол нэг эхэд ногдох дундаж тоо 4.0 байна.



Хүснэгт 8. Алдарт эхийн одонтой эхийн тоо, хүүхдээр, хороогоор

Захиргаа	Алдарт эхийн одонтой нийт эх	Нийт хүүхдийн тоо	Алдарт эхийн I одонтой эх	Хүүхдийн тоо	Алдарт эхийн II одонтой эх	Хүүхдийн тоо
Дүүргийн дүн	6 945	32 334	1 822	11 809	5 123	20 525
1-р хороо	136	630	26	171	110	459
2-р хороо	96	320	25	122	71	198
3-р хороо	233	1 071	45	323	188	748
4-р хороо	194	921	44	292	150	629
5-р хороо	190	906	43	292	147	614
6-р хороо	253	1 078	58	373	195	705
7-р хороо	752	3 476	169	1 102	583	2 374
8-р хороо	226	1 064	59	378	167	686
9-р хороо	344	1 663	84	580	260	1 083
10-р хороо	347	1 832	102	781	245	1 051
11-р хороо	285	1 353	80	510	205	843
12-р хороо	638	2 834	217	1 286	421	1 548
13-р хороо	453	2 100	118	707	335	1 393
14-р хороо	376	1 764	104	672	272	1 092
15-р хороо	510	2 428	146	928	364	1 500
16-р хороо	693	3 386	155	1 129	538	2 257
17-р хороо	419	1 926	120	802	299	1 124
18-р хороо	270	1 172	63	376	207	796
19-р хороо	530	2 410	164	985	366	1 425

➤ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМ

Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо 4183 болж өмнөх оны мөн үеэс 82 (2.0%) хүнээр буурсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний 1739 (41.6%) нь эмэгтэйчүүд, 616 (14.7%) нь 0-17 насны хүүхэд, 104 (2.5%) нь 65 түүнээс дээш насны хүн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй болсон шалтгаанаар авч үзвэл 1800 буюу 43.0 хувь нь төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй, 2114 буюу 50.5 хувь нь өвчнөөр, 269 буюу 6.5 хувь нь осол гэмтлийн улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.


Дүүргийн 0-17 насны хүүхдийн 616 (1.2%) нь хөгжлийн бэрхшээлтэй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг өвчний төрлөөр авч үзвэл 48 (7.8%) нь харах эрхтний өөрчлөлттэй, 45 (7.3%) нь сонсголын бэрхшээлтэй, 35 (5.7%) нь ярианы бэрхшээлтэй, 101 (16.4%) нь хөдөлгөөний бэрхшээлтэй, 132 (21.4%) нь сэтгэцийн эмгэгтэй, 72 (11.7%) нь хавсарсан согогтой, 183 (29.7%) нь бусад өвчний төрөлд хамрагдаж байна.

Дүүргийн хэмжээнд сургуулийн өмнөх боловсролд хөгжлийн бэрхшээлтэй 27 хүүхэд хүмүүжиж байна.

Хүснэгт 9. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын тоо, төрлөөр, оноор

Үзүүлэлт	Хичээлийн жил				
	2015-2016	2016-2017	2017-2018	2018-2019	2019-2020
Нийт дүн	29	23	41	18	27
Харааны	3	3	10	2	2
Сонсголын	3	3	3	1	1
Хэл ярианы	5	2	8	2	2
Оюуны	3	3	3	-	-
Хөдөлгөөний	4	5	8	9	8
Аутизм	-	-	-	2	4
Дауны хам шинж				2	6
Хавсарсан	11	7	9	-	4

Зураг 9. Хөгжлийн бэрхшээлтэй хүн, өвчний төрлөөр, хувиар, 2019 он



Хөгжлийн бэрхшээлтэй хүний 3932 (94.0%) нь нийгмийн халамжийн тэтгэвэр тогтоолгосон, 585 (14.0%) нь хөдөлмөр эрхэлж байна.

Байнгын асаргаанд 1218 (29.1%) нь байгаа ба 552 (45.3%) нь эмэгтэйчүүд байна. Байнгын асаргаанд байгаа хөгжлийн бэрхшээлтэй 3 хүн тутмын 1 нь хүүхэд байна.

Хөгжлийн бэрхшээлтэй 0-17 насны 616 хүүхдийн 384 (63.1%) нь байнгын асаргаанд байна.

Хүснэгт 10. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, өвчний төрөл, насны бүлгээр, 2019

Үзүүлэлт	Бүгд	Хөгжлийн бэрхшээлийн төрөл								
		Эмэгтэй	Хөдөлмөр эрхэлдэг	Төрөлхийн	Олдмол	Өвчнөөр		Осол гэмтлээр		
						Ердийн өвчин	Мэргэжлээс шалтгаалсан өвчин	Зам тээврийн осол	Үйлдвэрлэлийн осол	Ахуйн осол
Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо	4 183	1739	628	1 800	2 383	2 012	102	87	55	127
0-4 нас	112	38	-	78	34	34	-	-	-	-
5-9 нас	202	65	-	145	57	55	1	-	-	1
10-14 нас	211	89	-	149	62	59	2	-	1	-
15 нас	38	14	-	22	16	16	-	-	-	-
16 нас	23	7	1	13	10	10	-	-	-	-
17 нас	30	10	1	21	9	9	-	-	-	-
18 нас	39	14	3	31	8	8	-	-	-	-
19 нас	27	9	1	16	11	10	-	1	-	-
20-34 нас	853	354	156	441	412	354	17	20	10	11
35-64 нас	2544	1078	464	862	1682	1383	77	65	43	114
65, түүнээс дээш нас	104	61	2	22	82	74	5	1	1	1




ӨРХИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Нийслэлийн Чингэлтэй дүүрэгт 2019 онд 39345 өрх оршин сууж, өрхийн ам бүлийн дундаж тоо 3.8 болсон байна. Өрхийн тоо 1992 оноос 21960 өрхөөр буюу 1.5 дахин өссөн бол өмнөх оноос 672 (1.5%) өрхөөр буурсан байна. Чингэлтэй дүүрэгт Монгол Улсын нийт өрхийн 4.4 хувь, Нийслэл хотын нийт өрхийн 9.6 хувь нь байнга оршин сууж байна.

Хүснэгт 11. Монгол Улс, Нийслэл хотын өрхийн тоо, дүүргээр, оноор

Захиргаа	2015	2016	2017	2018	2019
Монгол Улсын нийт өрх	859 106	869 849	885 639	894 496	897 427
Нийслэлийн дүн	376 419	380 828	386 218	387 453	411 420
Чингэлтэй	41 540	40 589	40 548	40 017	39 345
Багануур	8 462	8 604	8 514	8 569	8 133
Багахангай	1 193	1 187	1 196	1 272	1 131
Баянгол	57 981	58 241	58 756	59 536	62 976
Баянзүрх	93 097	93 713	94 971	95 714	104 764
Налайх	10 051	10 349	10 547	10 606	10 248
Сонгиохайрхан	82 895	84 924	86 212	84 236	93 521
Сүхбаатар	37 920	38 021	38 272	38 563	40 061
Хан-Уул	43 280	45 200	47 202	48 940	51 241




Хүснэгт 12. Чингэлтэй дүүргийн өрхийн тоо, хороогоор, оноор


Захиргаа	2015	2016	2017	2018	2019
Дүүргийн дүн	41 540	40 589	40 548	40 017	39 345
1 -р хороо	939	935	936	931	922
2 -р хороо	888	975	978	924	993
3 -р хороо	1 612	1 610	1 632	1 703	1 669
4 -р хороо	1 460	1 549	1 304	1 394	1 305
5 -р хороо	1 261	1 308	1 286	1 245	1 221
6 -р хороо	2 065	2 002	2 005	2 035	2 314
7 -р хороо	3 369	3 361	3 376	3 282	3 250
8 -р хороо	1 243	1 206	1 178	1 165	1 068
9 -р хороо	1 830	1 753	1 740	1 747	1 778
10 -р хороо	1 912	1 808	1 839	1 817	1 694
11 -р хороо	1 553	1 463	1 421	1 409	1 358
12 -р хороо	3 773	3 727	3 727	3 662	3 523
13 -р хороо	2 040	2 006	2 004	1 952	1 961
14 -р хороо	2 083	2 026	1 944	1 981	1 781
15 -р хороо	2 160	2 201	2 387	2 223	2 207
16 -р хороо	3 441	2 988	2 992	3 189	3 291
17 -р хороо	4 066	3 868	3 872	3 715	3 640
18 -р хороо	2 703	2 560	2 701	2 497	2 419
19 -р хороо	3 142	3 243	3 226	3 146	2 951

Гэрлэлтээ бүртгүүлсэн өрхийн тоо 2019 онд 1000 болж өмнөх оноос 146 (12.7%) өрхөөр буурсан байна. Нийт өрхийн 994 (99.4%) нь гэрлэлтээ шинээр бүртгүүлсэн хос байгаа бол 6 (0.6%) нь гэрлэлтээ дахин сэргээсэн хос байна. Гэрлэлтээ батлуулсан хүний 78.5 хувь нь 25-34 насны хос байна.

Зураг 9. Гэрлэсэн хос, насны ангиллаар, хувиар



Зураг 10. Гэрлэлтээ цуцалсан хос, хамт амьдарсан жилээр, хувиар




Шүүхийн шийдвэрээр 288 хос гэрлэлтээ цуцлуулсан нь өмнөх оноос 29 буюу 9.1 хувиар буурсан байна. Гэрлэлтээ цуцлуулсан хосын 39.4 хувь нь 30-39 насны хүн байна.

Өндөр настай ганц бие өрх 2019 оны жилийн эцсийн байдлаар 568 болж өмнөх оны мөн үеэс 9 (1.6%) буурсан байна. 18 хүртэл насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх 1508 бүртгэгдэж өмнөх оноос 229 (17.9%) өрхөөр нэмэгдсэн байна. Мөн өрх толгойлсон хүн 2168 болж 8.4 хувиар буурсан байна.

Дүүргийн нийт өрхийн 78.5 хувь нь зөөврийн үндны үс хэрэглэдэг ба сайжруулсан ариун цэврийн байгууламжид холбогдоогүй байна.

Нийслэлийн мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэр хамрагдаж байгаа тул 2019 оны “Мал, тэжээвэр амьтдын тооллого”-оор мал тоологдоогүй. Харин 7 хорооны 31 өрхөд 375 тэжээвэр амьтан тоологдсон байна.

2019 ОНЫ ТЭЖЭЭВЭР АМЬТАДЫН ТОО -375



Дүүргийн нийт өрхийг сууцны төрлөөр нь авч үзвэл 8831 өрх буюу 22.4 хувь нь нийтийн орон сууцанд, 308 өрх буюу 0.8 хувь нь бие даасан тохилог сууцанд, 18748 өрх буюу 47.7 хувь нь сууцны тусдаа байшинд, 11429 өрх буюу 29.0 хувь нь монгол гэрт амьдарч байгаа бол 29 өрх буюу 0.1 хувь нь өөрсдийн гэсэн орон гэргүй амьдарч байна.

Хүснэгт 12. Өрхийн тоо, сууцны төрлөөр, хороогоор, 2019 он

Захиргаа	Нийт өрхийн тоо	Нийтийн орон сууцанд амьдардаг	Тусдаа тохилог орон сууц амьдардаг	Байшинд амьдардаг	Монгол гэрт амьдардаг	Орон гэргүй /тэнэмэл/
Дүүргийн дүн	39 345	8 831	308	18 748	11 429	29
1 -р хороо	922	922	-	-	-	-
2 -р хороо	993	993	-	-	-	-
3 -р хороо	1 669	1 669	-	-	-	-
4 -р хороо	1 305	1 304	-	-	-	1
5 -р хороо	1 221	1 221	-	-	-	-
6 -р хороо	2 314	2 314	-	-	-	-
Байшин хорооллын дүн	8 424	8 423	-	-	-	1
7 -р хороо	3 250	-	137	1 676	1 423	14
8 -р хороо	1 068	-	-	757	306	5
9 -р хороо	1 778	-	-	1 222	556	-
10 -р хороо	1 694	300	-	802	589	3
11 -р хороо	1 358	-	9	938	410	1
12 -р хороо	3 523	-	5	1 850	1 665	3
13 -р хороо	1 961	-	-	1 356	605	-
14 -р хороо	1 781	84	-	1 133	564	-
15 -р хороо	2 207	24	-	1 609	574	-
16 -р хороо	3 291	-	41	2 007	1 243	-
17 -р хороо	3 640	-	30	2 090	1 520	-
18 -р хороо	2 419	-	-	1 623	796	-
19 -р хороо	2 951	-	86	1 685	1 178	2
Гэр хорооллын дүн	30 921	408	308	18 748	11 429	28




ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ӨРХ, ХҮН АМ 2019



Өрхийн ам бүлийн дундаж тоо 3.8 байна.

Чингэлтэй дүүрэг анх байгуулагдсан 1992 оноос хойш өрхийн тоо 1.5 дахин өссөн байна



0-15 нас

48306

16-59 нас

88747

60, түүнээс
дээш нас

11924

ХӨГЖЛИЙН
БЭРХШЭЭЛТЭЙ
ИРГЭН 4183



ГЭРЛЭЛТ
1000



ЦУЦЛАЛТ
288



ШИНЭ ТӨРСӨН
ХҮҮХЭД
3863



ӨРХ, ХҮН АМЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

2018 он



НИЙТ ӨРХ 40017